



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ДУНДГОВЬ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,  
Сайнцагаан сум, Нарлаг баг  
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08  
E-mail: dundgovi@audit.gov.mn

БАЯНЖАРГАЛАН СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Т.ЦЭВЭЛМАА ТАНАА

2016.11.11

№

01/167

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 1.9, аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудитаар нийт 34,556,119.00 /Гучин дөрвөн сая таван зуун тавин зургаан мянга нэг зуун арван ес/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ.

1. Шатахууны зардлаас зориулалт бусаар зарцуулж нийт 1,000,000.00 төгрөгийг зардалд тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, 14.3.1-т /анхан шатны баримт бүрдүүлэх/ заасныг тус тус зөрчсөн байна.

2. Цалин, урьдчилгаа олгохдоо ажилчдын картаар олгох цалингийн жагсаалт хийгээгүй 30,117,246.00 төгрөгийг нэрийн дансыг бичилгүй шилжүүлж анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж баримтжуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, 14.3.1-т /анхан шатны баримт бүрдүүлэх/ заасныг зөрчсөн байна.

3. Шатахууны 3,438,873.00 төгрөгийн зардлыг тооцохдоо анхан шатны хүчин төгөлдөр бус баримтаар тооцож зардалд тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/ заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан

Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй / заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Санхүүгийн анхан шатны баримтыг үнэн, зөв бүрдүүлж баримтжуулж хэвших
2. Цалин олгохдоо ажилчдын картаар олгох, цалингийн жагсаалт хийж нэрийн дансаар олгон баримтжуулж байх
3. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх
4. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дугаар сарын 10-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын дарга /Т.Цэвэлмаа/, нягтлан бодогч /Ц.Наранжаргал/ нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН<sup>1</sup>:

ШИНЖЭЭЧ



Ж.УГТАХБАЯР

ДАРГА

НЯГТЛАН БОДОГЧ

ЗӨВШӨӨРСӨН:



Т.ЦЭВЭЛМАА

Ц.НАРАНЖАРГАЛ

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.